ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 24 өдөр Дугаар 49 Чойбалсан

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23, 10 дугаар зүйлийн 10.7, 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3.2, $27^1$ дүгээр зүйлийн $27^1.1.1$, $27^1.1.2$, $27^1.1.3$, $27^1.1.4$, $27^1.2$, $27^1.3$, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 104 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 41 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт хязгаарлахгүй үйл ажиллагааны горимыг дараахь байдлаар тогтоосугай.

1.1.Төрийн байгууллагын үйл ажиллагааны хувьд хууль тогтоох, төрийн захиргааны байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Авлигатай тэмцэх газар, аймаг, сумын Сонгуулийн хорооны ажилтан албан хаагчид 10 хүртэл хувиар ажиллах, Эрүүл мэндийн байгууллага, Байгаль орчныг хамгаалах, Гааль, Онцгой байдал, Мэргэжлийн хяналт, Зэвсэгт хүчин бусад цэрэг, Татвар, Гадаадын иргэний харьяат, Улсын бүртгэл, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шүүх, Прокурорын байгууллага, зайны сургалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ, асрамж, халамж, түр хамгаалах байрны ажилтан, албан хаагчид халдвар, хамгааллын дэглэм мөрдөн ажил үүргээ гүйцэтгэх ба хөдөлгөөнд оролцох цагийн горимыг 08:30-18:00 цагийн хооронд байхаар тогтоосугай.

1.2.Хуулийн этгээдийн үйл ажиллагааны хувьд эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, өмгөөлөл, нотариат, аймгийн Улаан загалмайн хороо, автомат тооцооны машин, хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт, сав баглаа боодол, харилцаа холбоо, шуудан илгээмж, улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа /тусгай цагийн хуваарьтай ажиллах, Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолыг баримтлах/, хэвлэл мэдээлэл (эрх хязгаарлах), зам, барилга, эрчим хүч, инженерийн байгууламж дулаан, усан хангамж, нийлүүлэлт, түгээлт, тусгай зөвшөөрөл бүхий

010221221

байгууллагын түлшний тээвэрлэлт, ариутгал халдваргүйжүүлэлт, хог хаягдал, хог хаягдлын цэвэрлэгээ ачилт, цуглуулалт, тээвэрлэлт, геологи, хайгуул, уул уурхай, газрын тосны олборлолт, газар тариалан, мал амьтны өвс, тэжээлийн түгээлт, тээвэрлэлт, шатахуун, түлшний хангамж, түлш худалдан авах үйл ажиллагаа, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллага, орон сууц, нийтийн үйлчилгээний контор, сууц өмчлөгчдийн холбоо, оршуулгын үйл ажиллагаа халдвар хамгааллын дэглэм мөрдөн явагдах ба хөдөлгөөнд оролцох цагийн горимыг 07.00-21.00 цагийн хооронд байхаар тогтоосугай.

1.3.Хүний үйл ажиллагааны хувьд эмнэлгийн зайлшгүй тусламж, эмийн сан, өмгөөлөл, нотариат, түлш худалдан авах, хүнс, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан авах, газар тариалан эрхлэх, зөөврийн ус авах, шинжилгээ өгөх, оршуулгын ажилд оролцохоос бусад үйл ажиллагааг хязгаарласугай.

1.4.Иргэдийг эмнэлгийн тусламж үйлчилгээ зайлшгүй авах, оршуулгын үйл ажиллагаанд оролцох болон хязгаарлаагүй үйл ажиллагаа явуулах байгууллагын ажилтны хувьд ажилдаа ирэх, явах, ажил үүргээ гүйцэтгэх, засвар үйлчилгээ хийх, үйлдвэр түгээлт хийхээс бусад тохиолдолд автомашинаар хөдөлгөөнд оролцохыг хязгаарласугай.

2.Төрийн байгууллага, хуулийн этгээд, хүний үйл ажиллагаанд тогтоосон дээрх горимыг харъяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд мөрдүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.Хэрлэн сум /Чойбалсан хот/ доторх нийтийн тээврийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч /О.Пүрэв-Очир/-т даалгасугай.

4.Оршуулга, буяны үйл ажиллагаанд оролцсон иргэдээс халдвар тархах эрсдэл өндөр байгаа тул тодорхой хязгаарлалт, хүний тоог зааж зохион байгуулах талаар иргэдэд зөвлөмж, анхааруулга өгч, хяналт тавьж ажиллахыг сум, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Орон нутагт эрүүл мэндийн салбар, хариу арга хэмжээний баг, тандалт судалгааны баг, стратегийн ач холбогдол бүхий салбарын ажилтан, албан хаагчдыг дархлаажуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Халдвар бүртгэгдсэн сумдад хавьтал тогтоох, тандалт судалгааг эрчимжүүлэх, эрт илрүүлэх, зохион байгуулалтын бүх талын арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/, Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Д.Должин/, аймгийн ерөнхий тархвар судлаач эмч Б.Ганганцэцэг, сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

7.Баянхошуу, Эрээнцав хилийн боомт, хяналтын цэгүүдийн халдваргүйжүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/-т даалгасугай.

8.Уул уурхай, зам, барилга, эрчим хүч, инженерийн байгууламж, газар тариалан эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, алба хаагчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, тухайн объект, ажлын байранд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, ажлын тусгай горимоор ажиллуулахыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

9.Аймгийн Эрүүл мэндийн газрын Шуурхай штабт ирсэн иргэдийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, эргүүл хяналтаар ажиллах төрийн байгууллагын албан хаагчдыг нэмэлтээр дайчлан ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /П.Бат-Өлзий/-д даалгасугай.

10.Хязгаарлалтын хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг сахиж, мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг мөрдөж ажиллахыг төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үүрэг болгосугай.

11. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комиссын 2021 оны "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

12.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Онцгой комиссын орлогч дарга /Ч.Ганбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА